



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 39

Мандалговь


Хөрөнгө данснаас хасах тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.8.г дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 4,708,000 /дөрвөн сая долоон зуун найман мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, 167,799 /нэг зуун жаран долоон мянга долоон зуун ерэн ес/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг хавсралтын дагуу акталж устгахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, ОНӨА-ны хяналтан дор зохион байгуулж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Дашбалданд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ

Аймгийн ИТХТ-ийн 2015 оны 05 сарын  
28 өдрийн 32-р тогтоолын хавсралт

Акталж устгах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Ашиглалтанд орсон он	Үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Сандал	1	2008.12.31	19,000.0	19,000.0	11,500.0	7,500.0
2	Сандал модон	1	2003.06.25	90,450.0	90,450.0	90,450.0	-
3	Хар сандал	1	2006.12.24	105,450.0	105,450.0	84,360.0	21,090.0
4	Дрожи дэвсгэр	21	2006.06.25	34,371.0	721,791.0	721,791.0	-
5	Индүү	1	2002.03.27	15,000.0	15,000.0	15,000.0	-
6	Утасны тавиур	1	2002.01.15	10,421.4	10,421.4	10,421.4	-
7	Ус буцалгагч	1	2008.04.29	28,620.0	28,620.0	28,620.0	-
8	Компьютер	2	2002.05.07	881,376.3	1,762,752.6	1,762,752.6	-
9	Мебел ширээ	1	2009.01.01	8,753.8	8,753.8	8,753.8	-
10	Хогийн сав	6	2009.01.01	4,169.2	25,015.2	25,015.2	-
11	Тоос сорогч	1	2011.06.22	167,000.0	167,000.0	119,683.2	47,316.8
12	Тоос сорогч	1	2011.12.20	78,500.0	78,500.0	60,510.5	17,989.5
13	Ажилтны ширээ	1	2007.10.23	122,900.0	122,900.0	76,556.4	46,343.6
14	Будаа агшаагч	1	2008.04.29	45,000.0	45,000.0	45,000.0	-
15	Ажилтны сандал	1	2008.10.13	68,900.0	68,900.0	41,340.0	27,560.0
16	Компьютерийн шир	1	2000.04.12	57,888.0	57,888.0	57,888.0	-
17	Бризент	1	2005.12.31	190,592.0	190,592.0	190,592.0	-
18	Япон магнитфон	1	1989.05.08	48,843.0	48,843.0	48,843.0	-
19	Камер сони	1	2007.12.24	625,152.0	625,152.0	625,152.0	-
20	Шургуулга	3	2007.12.25	3,223.4	9,670.3	9,670.3	-
21	Дрожи дэвсгэр	8.9	2006.06.25	23,517.0	209,301.3	209,301.3	-
22	Зургийн аппарат	1	2011.12.20	297,000.0	297,000.0	297,000.0	-
Нийт дүн					4,708,000.6	4,540,200.8	167,799.8